



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

**Тусгай зөвшөөрөл олгох тухай**

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 1 /нэг/ хуулийн этгээдэд хиймэл дагуулаар олон суваг дамжуулах үйлчилгээнд “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн  
151-тоот тогтоолын  
хавсралт

Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн  
жагсаалт

| № | Хуулийн этгээдийн нэр  | Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж  | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|------------------------|--|---------------|----------------|
| 1 | Монголсат нэтворкс ХХК | Хиймэл дагуулаар олон суваг дамжуулах үйлчилгээнд ашиглах /14197.5МГц-14251.5МГц, 14319.5МГц-14373.5МГц/ | 2024.06.27    | 2029.06.27     |

----- оОо -----